



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Ж.Цогтбаярыг албан тушаалаас
чөлөөлөх тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18 компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.8 дахь хэсэг, Нэр дэвшүүлэх хорооны 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2024-06 дугаар дүгнэлт, Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаярын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн “Албан тушаалаас чөлөөлөгдөх” өргөдөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жадамба овогтой Цогтбаярыг түүний хүсэлтээр 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөр тасалбар болгон Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан тушаалаас чөлөөлж, түүний 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Хөлсөөр ажиллах гэрээ”-г дуусгавар болгосугай.
2. Ж.Цогтбаярыг албан тушаалаас чөлөөлсөнтэй холбоотойгоор үүрэгт ажлаа 2025 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөр тасалбар болгон хүлээлгэж өгөхийг үүрэг болгосугай.
3. Ж.Цогтбаярыг чөлөөлсөнтэй холбоотойгоор цалин хөлс, ээлжийн амралт, эд хөрөнгийн тооцоог дуусгавар болгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

•1525010003



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 76.1.18 дахь заалт, компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.8 дахь хэсэг, Нэр дэвшүүлэх хорооны 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2024-06 дугаар дүгнэлт, Сангийн яамны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 01/10762 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Баасандаваа овогтой Дөлгөөнийг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн томилсугай.
2. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулах хөлсөөр ажиллах гэрээний төслийг хавсралтаар баталсугай.
3. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн үүрэгт ажлыг Б.Дөлгөөнд 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр хүлээлцүүлж, энэхүү тогтоолын хавсралтаар баталсан гэрээг байгуулахыг тус тус Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Д.Тогтохбаяр)-д даалгасугай.
4. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөний сарын үндсэн цалинг төгрөгөөр тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Нарангэрэл)-д зөвшөөрсүгэй.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1525010004